



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 17 өдөр

Дугаар А/13

Номгон

Г 7
“Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийг
хэрэгжүүлэх арга хэмжээний 2024 оны
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Монгол улсад “Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийг батлах тухай Улсын Их Хурлын 2003 оны 41 дүгээр тогтоолын 4 дүгээр зүйлийн 4.4, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 17/59 дүгээр аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөг батлах тухай тогтоолын 2 дугаар хавсралтын 201 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2024 оны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх зардалд 2.0 (Хоёр сая) төгрөгийг аймгийн хөгжлийн төлөвлөгөөний арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

3. Дээрх төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж ажиглахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Д.Сарангарав)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д даалгасугай.




ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

642311979

Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 17/А дугаар захирамжийн хавсралт



ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв сая,төг	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа	Хариуцах албан хаагч
1	2	3	4	5	6	7	8
Хүний эрхийг хангах чиглэлээрх бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг ханган ажиллах							
1	Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар сум, байгууллагын дарга эрхлэгч нарт чиглэл хүргүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих	-	Хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэл 1 удаа хүргүүлж хэрэгжилтийг хагас бүтэн жилээр авах	-	Эхний хагас жил 50% Сүүлийн хагас жил -45%	2024.01.10 2024.12.25	Хууль,эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Б.Анухатан
2	Засгийн газрын 2023 оны 357 дугаар тогтоолын хамаарал бүхий заалтын хэрэгжилтийг ханган ажиллаж НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан 2023-2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллана.	-	Хамаарал бүхий заалтуудын хэрэгжилтийг хангуулж ажилласан байна.	-	Эхний хагас жил 45% Сүүлийн хагас жил -45%	2024.01.10 2024.12.25	Хууль,эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Б.Анухатан
3	ЗГХЭГ-ын Хүний эрхийг хангах үндэсний хорооны 01 дүгээр тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж Хүний эрхийн төлөв байдлын тайланг хугацаанд нь тайлагнах, илтгэх	-	Хүний эрхийн төлөв байдлын тайланг хугацаанд нь тайлагнаж хуваарийн дагуу илтгэсэн байна	100%	Эхний хагас жил 55% Сүүлийн хагас жил -45%	2024.01.10 2024.12.10	Хууль,эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Б.Анухатан

1	2	3	4	5	6	7	8
4	Аймгийн хэмжээний гэмт хэрэг зөрчилд холбогдсон төрийн албан хаагчдын судалгаанд үндэслэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах	-	Цагдаагийн газраас ирүүлсэн судалгаанд үндэслэн албан бичиг хүргүүлж, зөрчлийн мэдээг нийтлэх	148 албан хаагч	Эхний хагас жил 50% Сүүлийн хагас жил -50%	2024.01.10 2024.12.10	Хууль,эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Б.Анухатан
5	Хүний зөрчигдсөн талаарх мэдээ, судалгаанд тулгуурлан хүний эрхийг хангах хамгаалах талаар арга зүйн зөвлөмжийг сумын Засаг дарга нарт хүргүүлж ажиллах	-	Судалгааг ХЭК-оос авч 1 удаа зөвлөмж хүргүүлнэ.	-	Эхний хагас жил 50% Сүүлийн хагас жил -50%	2024.01.10 2024.12.10	ХЭҮК-ийн референт Б.Содонцэцэг Хууль,эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Б.Анухатан
6	Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг сурталчлан таниулах ажил арга хэмжээг зохион байгуулах	400.000	Хуулийн хэрэгжилтийг хангаж арга хэмжээг зохион байгуулсан байна.	-	Эхний хагас жил 50% Сүүлийн хагас жил -50%	2024.01.10 2024.12.10	ХЭҮК-ийн референт Б.Содонцэцэг Хууль,эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Б.Анухатан
Хүний эрх, эрх чөлөөг хөхүүлэн дэмжих, хүний эрхийн боловсрол олгох ажлын хүрээнд							
7	Хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг жендэрийн сургагч багш нартай хамтран зохион байгуулах	300.000	Зорилтот бүлэг рүү чиглэсэн сургалтыг 2 удаа зохион байгуулсан байна.	1	Эхний хагас жил 50% Сүүлийн хагас жил -50%	2024.01.10 2024.12.10	Хууль,эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Б.Анухатан
8	Ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулж, Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих	-	Сургалтыг 2 удаа зохион байгуулж, хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.	1	Эхний хагас жил 50% Сүүлийн хагас жил -50%	2024.01.10 2024.12.10	Хууль,эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Б.Анухатан
9	Зорилтот бүлгийн эмэгтэйчүүд рүү чиглэсэн нөлөөлийн арга хэмжээ зохион байгуулах	1.0	Нөлөөлийн арга хэмжээг төлөвлөгөө	-	Эхний хагас жил 100%	2024.01.10 2024.12.10	Хууль,эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн

1	2	3	4	5	6	7	8
			боловсруулан зохион байгуулж үр дүнд хүрсэн байна.				Б.Анухатан
10	Хүүхдийн эрхийг хамгаалах Олон Улсын өдрийг тохиолдуулан зохион байгуулах	300.000	Хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх 1 сарын аян зарлаж үр дүнг тооцон ажиллах	-	Эхний хагас жил 100%	2024.01.10 2024.12.10	Хууль,эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Б.Анухатан
Хүний эрх зөрчигдсөн асуудлын талаар иргэдээс ирсэн өргөдөл гомдол шийдвэрлэлтийн талаар							
11	Хүний эрхийн зөрчлийн талаарх иргэдээс Төрийн байгууллага албан тушаалтанд ирүүлсэн гомдол мэдээллийг холбогдох албан тушаалтанд уламжилж шийдвэрлүүлэх, судалгааны сан бүрдүүлэх	-	Иргэдээс бичгээр Төрийн байгууллага албан тушаалтанд ирүүлсэн гомдол мэдээллийн шийдвэрлэлтийн судалгааны сан бүрдүүлэх	-	Эхний хагас жил 50% Сүүлийн хагас жил -50%	2024.01.10 2024.12.10	Хууль,эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Б.Анухатан
12	Хүний эрхийн зөрчлийн талаарх Засгийн Газрын 1111 төв өгсөн гомдолын дагуу холбогдох байгууллагад дамжуулах хуулийн хугацаанд шийдвэрлүүлэх	-	Хүний эрхийн зөрчлийн талаар гомдолыг хуулийн хугацаанд шийдвэрлүүлэх	-	Эхний хагас жил 50% Сүүлийн хагас жил -50%	2024.01.10 2024.12.10	Хууль,эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Б.Анухатан